

“ХҮНСНИЙ НОГОО” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Сайншанд

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
Зорилт 1. Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах					
1	1. Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй байгуулахад урт хугацаатай зээлийн эх үүсвэр бий болгох, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллагын санхүүжилтээр загвар, цогцолбор аж ахуй байгуулна	2018 - 2022		<p>Хүлэмжийн аж ахуйн хувьд 900 м2 өвлийн хүлэмж, 10520 м2 зуны хүлэмжид тариалалт хийж, урьд оноос хамгаалагдсан хөрсний тариалалтыг 579 м2-аар нэмэгдүүлсэн.</p> <p>Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дэмжих төсөл”-ийн 120,0 мянган долларын санхүүжилтээр аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн Сайншанд суманд 2 га талбайд өвөл /200м2/, зун /360м2/-ы хүлэмжийн аж ахуйн цогцолбор байгуулсан.</p> <p>“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаас газар тариалан эрхлэх сонирхолтой, боломжтой өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй 11 иргэнд 98,0 сая төгрөг, Хатанбулаг сумын бүлэг, нөхөрлөлд 60 м2 нийлэг хальсан хүлэмжийн иж бүрдлийг тус тус олгосон.</p> <p>“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлд 2 аж ахуйн нэгжид 72,0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 9 иргэн, аж ахуйн нэгжид 101,6 сая төгрөг, Засгийн газраас олгосон 3 хувийн зээлд 4 иргэн, 1 хоршоо 69,6 сая төгрөг нийт 26 иргэн, аж ахуй нэгжид 341,2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.</p> <p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр Дорноговийн тариаланчид төрийн бус байгууллагын 10 гишүүнд 6:20 хэмжээтэй 11 нийлэг хальсан хүлэмж олгосон. Мөн хувийн хөрөнгө оруулалт нийт 20,0 сая төгрөгөөр 360 м2 талбай бүхий 3 хүлэмжийг байгуулснаар нийт 10520 м2 талбайд хамгаалагдсан хөрсний тариалалт хийсэн.</p>	100%
2	2. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг ялгах, савлах, хатаах тоног төхөөрөмж, хадгалалтын шинэ арга технологийг	2018 - 2022		<p>Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсаар хүнсний ногоо зөв тариалах, холимог тариалалт, бордоо сонголт хүнсний ногоог хөлдөөх, ангилах чиглэлээр бэлтгэсэн 4 төрлийн видео хичээлийг давхардсан тоогоор 9350 иргэнд хүргэсэн.</p> <p>“Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг”</p>	50%

	нэвтрүүлнэ.			төслийн хүрээнд Эрдэнэ, Дэлгэрэх, Хөвсгөл сумдын газар тариалан эрхлэгч болон малчдын 45 төлөөллийг Төв аймгийн Баян-Чандмань сумын хүлэмжийн аж ахуй, техник тоног төхөөрөмж, тэжээлийн ургамал тариалахтай танилцуулан туршлага судлуулсан. Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол ногоо” төсөлтэй хамтран аймгийн 5 ногоочныг Төв аймгийн “Атрын шим” ХХК-д 3 хоногийн дадлага, сургалтад хамруулсан.	
3	3. Хүнсний ногооны таримлын нэр төрлөөр бүртгэл үйлдэн мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлнэ	2018 - 2022		<p>Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн 10 нэр төрлийн хүнсний ногооны 1 тонн тутамд 0,1 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгох бэлтгэл ажлын хэлэлцүүлгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн Татварын хэлтэстэй хамтран 2022 оны 08 дугаар сарын 17-нд Сайншанд суманд зохион байгуулж 13 сумын Газар тариалангийн мэргэжилтэн болон тариаланчдын төлөөлөл нийт 62 иргэн, аж ахуй нэгжийг хамруулсан.</p> <p>Газар тариалангийн цахим системд тус аймгаас 136 тариаланч бүртгүүлэхээс 09 сарын 23-ны өдрийн байдлаар 103 иргэн, 12 хуулийн этгээд бүртгэгдсэн. 2022 оны хаврын тариалалтаар нийт 25,8 га талбайд төмс, 63,2 га талбайд хүнсний ногоо, 33,90 га талбайд малын тэжээл, 15,20 га талбайд жимс жимсгэнэ тариалж нийт 558,3 тн ургац хураан авсан нь өмнөх онтой харьцуулахад тариалсан талбайн хэмжээ 29 %-иар, ургац 33,2 хувиар өссөн. Хүнсний ногоо тариалж буй иргэн, аж ахуйн нэгж, таримлын нэр төрөл тус бүрийн мэдээллийг plant.mofa.gov.mn цахим системд хөтлөн мэдээллийн сан үүсгэсэн.</p>	100%
Зорилт 2. Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх					
4	1. Газар тариалангийн бүсүүдэд хүнсний ногоо тариалахад тохиромжтой эрчим хүч, усны зарцуулалт багатай, байгаль орчинд халгүй, хямд өртөгтэй дуслын усалгааны дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	2018 - 2022		<p>“Мөрөөдлийн Говь” ХХК Эрдэнэ суманд хувийн хөрөнгө болох 23 сая төгрөг, Сайншанд сумын бүлэг ногоочид нэгдэн хувийн хөрөнгө болон 20 сая төгрөг нийт 43 сая төгрөгөөр газар тариалангийн бүсэд гүн өрмийн худгийг хоёроор нэмэгдүүлсэн.</p> <p>Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд “Газар тариалан эрхлэлт ойжуулалтыг дэмжих сан”, “Хоршоо хөгжүүлэх сан”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаас нийт 26 иргэн, аж ахуй нэгжид 341,2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж 960 м2 талбай бүхий дуслын усалтын системтэй зуны хүлэмжийг нэвтрүүлэн ажилласан.</p> <p>Говийн бүсийн онцлогоос шалтгаалан газар тариалангийн үйлдвэрлэлд гүний ус татан ашигладаг тул 197,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр 15 га талбайд дуслын усалгааны систем нэвтрүүлснээр хамгаалагдсан хөрсний тариалалтад усны зарцуулалт багатай дуслын усалгааны системийг 100% бүрэн нэвтрүүлсэн.</p>	100%
5	2. Өрхийн тариалалтад ашиглагдаж буй техник,	2018 - 2022		Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж нь төмс 25,838 га, хүнсний ногоо 63,263 га, малын тэжээл 33,90 га, жимс, жимсгэнэ	100%

	тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хийнэ.			<p>15,20 га, нийт 138 га талбай, бага оврын трактор 72, үрлэгч 5, ухагч 3, 37 га талбайн дуслын усалгааны систем, 900 м2 өвлийн хүлэмж 2 ширхэг, 10520 м2 зуны хүлэмж 65 ширхэг, 950 тонны багтаамж бүхий 22 зоорийг ашигладаг. 2020 оноос тариалангийн талбайн хэмжээ 29%, зоориний хангамж 10,5%, техникийн хангамж-21,6%, хамгаалагдсан хөрсний тариалалт 579 м2-аар нэмэгдсэн.</p> <p>“Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагаас Эрдэнэ, Хөвсгөл, Дэлгэрэх сумдад хэрэгжүүлсэн “Гамшигт тэсвэртэй хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Эрдэнэ, Дэлгэрэх сумдад 4 га талбайд малын тэжээлийн ургамлыг туршилтаар тариалж, бороожуулах усалгааны систем, бага оврын хадлангийн трактор, анжис, хадуур, тармуур, хаман боогч зэрэг 70,2 сая төгрөгийн техникийн шинэчлэл хийсэн.</p> <p>“Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 14 сумын /давхардсан тоогоор/ 432 иргэн, аж ахуйн нэгж, хоршоо, нөхөрлөл, малчид оролцож бараа, бүтээгдэхүүнээ сурталчлан 296,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Тус онд хүлэмжийн тариалалтыг 579 м2, 50 тонны багтаамж бүхий механик зоорь 1 шинээр ашиглалтад орж, 10520 м2 талбай бүхий зуны, 900 м2 талбай бүхий өвлийн хүлэмж, 1010 тн багтаамжтай зоорийг ашигладаг болсон.</p> <p>Америкийн нэгдсэн улсын Олон улсын Хөгжлийн агентлагийн санхүүжилтээр байгуулагдсан “Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагын "Бест" /BEST/ хөтөлбөрт орон нутгийн нийт 6 тариаланчийг хамруулж үр олгосон ба нэг аж ахуй нэгжид зээлийн зуучлалын үйлчилгээ үзүүлсэн. Газар тариалангийн чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож буй техник тоног төхөөрөмжийг танилцуулгыг давхардсан тоогоор 700 гаруй иргэд, тариаланчдад цахим хуудсаар дамжуулан мэдээлэл өгсөн.</p>	
6	3. Хүнсний ногоог ялгаж дугаарлах, сортлох, савлах хатаах тоног төхөөрөмж, гар багажны хангамжийг сайжруулах;	2018 - 2022		<p>Хүнсний ногоог гүн хөлдөөж хадгалах арга технологийн талаар цахим сургалтыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан 4 удаа зохион байгуулж 9350 орчим иргэдийг хамруулсан. Жижиг, дунд үйлдвэрийн газраас зохион байгуулсан "Хоршоонд суурилсан тогтвортой хөдөө аж ахуй" сэдэвт сургалтад "Мөнх ашиг" хоршооны төлөөллийг хамруулан хүнсний ногоог ангилах, савлах, хатаах технологийн талаар туршлага судлуулсан.</p>	50%
Зорилт 3. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг дэмжиж, ирээдүйтэй болон нутагшсан сортыг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн үрийн чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх					
7	1. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг хөгжүүлэх гарал үүсэл нь тодорхой, чанарын баталгаатай торгон сортын болон эрлийз үр үйлдвэрлэж, нэр	2018 - 2022		<p>Агропарктай хамтран “Монгол ногоо” төслөөс шинээр нэвтрүүлсэн төмс, хүнсний ногооны 23 сорт туршин хийсэн. Агропаркийг түшиглэн газар тариалангийн чиглэлийн 10 удаагийн сургалтыг зохион байгуулж 341 ногоочин хамруулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас олгосон /давхардсан тоогоор/ 53 нэр төрлийн хүнсний ногооны үрийг хөнгөлөлттэй үнээр 14 суманд хуваарилан олгосон.</p> <p>Үр үржүүлэх зорилгоор 80 хувийн хөнгөлөлттэй үнээр 2 тн элит төмсний үрийг</p>	

	төрлийг нэмэгдүүлнэ.			<p>“Мөнх-Ашиг” хоршоо, “Оюун шанд” ХХК-д нийлүүлсэн нь хангамжийг 2,57 хувиар тариалалтыг 3,1 хувиар нэмэгдүүлсэн. Шинээр солонгосын бууцай, байцаа, салат навчны 3-н төрлийн сортыг тариалан туршихаар сумдад үрийг хуваарилсан. Сорт сорилтын ажлын хүрээнд тарвас, амтат гуаны 2, эртийн байцайны 1, сонгино 1, тарвасын 1, саримс 1, бууцай 1, гүзээлзгэнэ 1, чавганы 40 ширхэг суулгац, нийт 9 төрлийн сортыг шинээр туршиж, амтат гуаны 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулахаар холбогдох газарт хүргүүлсэн. “Мөнх-Ашиг” хоршоо нь хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн ажлын хүрээнд сухай 100 кг төл, тагар сонгинын 200 кг төл, тарвас 23 кг амтат гуаны 25,4 кг үр тус тус гарган авч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх “Монгол ногоо” төсөлд нийлүүлсэн.</p> <p>“Дорноговийн тарвас” хөтөлбөрийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх улсын сорт сорилтын зөвлөлийн хурлаар тус аймагт тариалагддаг Астарханьский сортыг нутагшсан сортоор батлуулж, аймгийн хэмжээнд анх удаа нутагшсан сорттой болон, тарвасын үрийн сан бүрдүүлж, орон нутгийн хэрэгцээг 100% хангасан.</p>	100%
8	2. Хүнсний ногооны үрийн тариалан эрхлэгчдэд сэлгээний талбай нэмж олгох ажлыг зохион байгуулах.	2018 - 2022		<p>Тариалалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд 38.11 га талбайд хүнсний ногоо тариалсан. Шинээр хүнсний ногоо тариалах зориулалтаар Даланжаргалан сум 2 иргэнд 2 га газар, Айраг сум 5 иргэнд 5 га газар эзэмшүүлсэн.</p>	70%
Зорилт 4. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах					
9	1. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд ногоочин, техникийн ажилтан бэлтгэх сургалтад хөнгөлөлттэй нөхцлөөр сургах, мэргэшүүлэх	2018 - 2022		<p>Политехникийн коллеж-ийг түшиглэн орон нутагт нэн шаардлагатай байгаа хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ, фермерийн аж ахуйн ангийг шинээр нээн мэргэжилтэй ажилтан бэлтгэж эхэлсэн. Үүнээс 25 суралцагч төгсөж, шинээр 35 элсэгч суралцаж байна. Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран 20 ногоочныг газар тариалангийн мэргэжлээр бэлтгэсэн.</p>	100%
10	2. Тариаланчид, мэргэжилтнүүдийг гадаад орнуудын үр үйлдвэрлэх, хүлэмжийн аж ахуй, усалгааны шинэ техник, зоорийн тоног төхөөрөмжтэй танилцуулах, олон улсын үзэсгэлэнд оролцуулах,	2018 - 2022		<p>Тариалан эрхлэгчдийг чадавхжуулах, мэргэшсэн ажилтан бэлтгэх ажлын хүрээнд "Дэлхийн зөн Монгол" Олон Улсын Байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төсөл, “Монгол ногоо” төсөл, Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн яамтай хамтран 2021-2022 онд 7 удаагийн танхимын сургалт, 8 удаагийн цахим сургалт, 1 удаагийн туршлага солилцох аялал зохион байгуулан давхардсан тоогоор нийт 645 тариаланчийг хамруулсан. Төслийн хүрээнд Эрдэнэ, Дэлгэрэх, Хөвсгөл сумдын газар тариалан эрхлэгч болон малчдын 45 төлөөллийг Төв аймгийн Баян-Чандмань сумын хүлэмжийн аж ахуй, техник тоног төхөөрөмж, тэжээлийн ургамал тариалахтай танилцуулан туршлага судлуулсан.</p>	100%

	сургаж дадлагажуулах замаар хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлийн шинэ технологи эзэмшүүлэх			<p>Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол ногоо” төслөөс 5 ногоочныг Төв аймгийн “Атрын шим” ХХК-д 3 хоногийн дадлага, сургалтад хамруулсан. Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо, Европын холбооны SECiM төсөлтэй хамтран “Хүлэмжийн нарийн ногоо тариалах агротехник ба хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцоо” сэдэвт сургалтанд “Мөнх ногоон шанд” ХХК-ын төлөөллийг хамруулсан.</p> <p>Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөн буйр аймгийн Хайлаар хотод зохион байгуулагдсан "Ногоон хөгжил" Олон Улсын үзэсгэлэн яармагт тус аймгаас 5 хүний төлөөллийг хамруулж шинэ техник, технологи, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн үйлчилгээг сонирхон туршлага судлуулж хамтын түншлэлээ бэхжүүлсэн.</p>	
11	3. Хүн амд дотоодын хүнсний ногоог зохистой хэрэглэхийн ач тусыг ойлгуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах	2018 - 2022		<p>Зөв зохистой хооллолт, тэжээллэг хүнс, шим тэжээл, хүнсний ногооны хадгалалт, тээвэрлэл, зөв хэрэглээний чиглэлээр 6 удаагийн сургалтад 294 иргэнийг хамруулж мэдлэг олгосон.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны судалгаа хөгжлийн төв, Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн, багш нартай хамтран “Газар тариалангийн зохистой дадал, ач холбогдол, бүртгэл, хөтлөлт”, “Газар тариалангийн гаралтай бүтээгдэхүүний баталгаажуулалт олгох үйл явц”, “Элементүүд ба Ургамал хамгааллын цогц арга”, “Бордоог зохистой хэрэглээ”, “Хүлэмжийг аж ахуй эрхлэлт”, “Ургамал хамгааллын гарын авлага”, “Хүнсний ногооны голлох таримлын агротехнологи, сонгилог ургамал тариалах арга”, “байцай тариалах арга” сэдвүүдийн хүрээнд 5 төрлийн гарын авлага 3 удаагийн видео хичээлийг явуулж давхардсан тоогоор 3780 иргэнд мэдээлэл хүргэсэн.</p>	100%
12	4. Хүнсний ногоо тариалах, арчлах, ургацыг хадгалах, боловсруулах технологи, арга ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, сурталчлах ажиллагааг өргөжүүлэх	2018 - 2022		<p>Хүнсний ногоо тариалах, арчлах, хүнсний ногоо, жимс жимсгэнийг хатааж, хөлдөөх арга технологи мөн хүлэмжинд ногоо тариалах арчлах, үрслэг ургуулах сэдвийн хүрээнд 10 удаагийн цахим сургалт хийж, мэдээллийг 1000 гаруй иргэнд хүргэсэн.</p> <p>Говийн бүсийн газар тариалан эрхлэгчдийн туршлага ажил хөдөлмөрийг олон нийтэд сурталчлах, тэргүүн түршлагыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр DTV телевизтэй хамтран “Сайн байна уу” нэвтрүүлгийг бэлтгэн орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэн нийт 10000 орчим хүний хандалт авсан.</p> <p>Өрхийн тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх, эрүүл хэв маягт хэвшүүлэх, хүнсний ногоо тариалах арга туршлагыг нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Манайх эко гэр бүл” цахим уралдааныг ерөнхий боловсролын сурагчид, өрхүүдийн дунд зохион байгуулж 6 сумын 23 өрх оролцоноос 10 өрхийг шалгаруулж, тэргүүн туршлагыг нь нийтэд түгээн</p>	100%

				дэлгэрүүлэн сурталчилсан ба тус арга хэмжээнд 2,0 сая төгрөг зарцуулсан.	
13	5. Хамгаалагдсан хөрсний аж ахуй эрхлэгчдийг харилцан туршлага судлуулах, гидропоник орчинд ургуулах арга, технологи нэвтрүүлэх, аймаг, орон нутагт үзүүлэх сургалт зохион байгуулах	2018 - 2022		<p>Дэлхийн зөн монгол олон улсын байгууллагаас “Гамшигт тэсвэртэй хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Эрдэнэ, Хөвсгөл, Дэлгэрэх сумдад 4 га талбайд малын тэжээлийн ургамлыг туршилтаар тариалсан. Дээрх төсөл хэрэгжиж буй сумдын 496 малчид, тариаланчдад "Малын тэжээлийн ургамал тариалах" 4 удаагийн танхимын сургалт, 1 удаагийн туршлага судлах аяллыг зохион байгуулсан.</p> <p>Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Хатанбулаг, Эрдэнэ сумдад нийт 67 га талбайд малын тэжээлийн ургамал тариалж 84,5 тн ургац хураан авсан. Сайншанд сумын 1 иргэн гидропоник орчинд тариалалт хийх туршилтыг эхлүүлж, эхний ээлжинд малын тэжээлийн ургамал амжилттай тариалсан.</p>	100%
Хэрэгжилтийн дундаж					90.0%

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

Ж.НАРАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭНГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Е.УРАНЧИМЭГ